

**МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ**  
**БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГЫН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦОО**  
**Хурлын тэмдэглэл**

Хурал 2025 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 15 цагаас МУИС-ийн хичээлийн байрны 320 тоотод эхлэв.

**ХУРЛЫН ИРЦ:** Ректор Б.Очирхуяг, АТС-ийн захирал Ц.Амартайван, ШУС-ийн захирал Б.Болд-Эрдэнэ, БС-ийн дэд захирал М.Эрдэнэбат, ХШУДАГ-ын дарга П.Лхамсүрэн, ЦШГ-ын дарга А.Баатарбилэг, ХЧБГ-ын дарга С.Булгантамир, ОХГ-ын дарга Б.Цэцэнцолмон, ХАГ-ын дарга Ш.Мэндбаяр, СХГ-ын дарга С.Эрдэнэ, ХОГ-ын Д.Бадмаанямбуу, ахлах мэргэжилтэн Б.Ганбат, аудитор Н.Мөнх-Эрдэнэ, мэргэжилтэн М.Саруул, Ж.Оюунбилэг Зөвлөх компанийн багш Г.Оргилмаа, Эрдэнэбаяр нар оролцов.

**ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:**

21001 стандартын шаардлагын дагуу дотоод аудиторуудын нэгдсэн тайланг танилцуулах, УДШ-ний үр дүн гарах тухай;

**СОНССОН НЬ:**

**П.ЛХАМСҮРЭН:** Бид дотоод нөөц бололцоогоороо ББМТ-нд дотоод аудит хийж дууслаа. Мөн гарын авлагаа танилцуулна.

**ХЭЛЭЛЦСЭН НЬ:**

*Г.Оргилмаа:* ISO 21001 стандартын дагуу дотоод аудитын тайлангийн загвар, үр дүнг боловсруулалцсан байгаа.

*Ц.Эрдэнэбаяр:* Зөвлөх үйлчилгээ үзүүлэгчийг төлөөлж Эрдэнэбаяр байна. Бид стандартыг 4 үнэлгээ өгч байгаа.

Нэгдүгээрт “Үл тохирол”. Шаардлага хангаагүй гэсэн үг. Нэг үл тохирол илэрсэн, энэ нь 9 дүгээр бүлэгт хамаарч байгаа багш, оюутан, ажилтнуудад сэтгэл ханамжийн судалгааг хийгээгүй тухай юм.

Хоёрдугаарт “Тохирол”, шаардлагад нийцэж байна гэсэн үг. МУИС-ийн хувьд 151 тохирол илэрсэн.

Гуравдугаарт “Сайжруулалт”, энэ нь сайжруулах боломжтой гэсэн үг, арай тохиролд хүрээгүй. Тухайлбал сонирхогч талуудын хэрэгцээ шаардлагад дүн шинжилгээ хийх хэрэгтэй. Үүнийг МУИС-ийн хэмжээнд, нэгжийн хэмжээнд хийх юм. Ажилтны хөгжлийн хөтөлбөр хоцрогдоод байна. Мэдээллийн харилцааг сайжруулах, мэдээллээ цэгцтэйг баталгаатай эх сурвалжаас мэдээлэх хэрэгтэй. Мөн оюутны байр, нөхцөл, үйлчилгээ, эцэг эхийн зүгээс тавьж байгаа шаардлага, санал гомдлыг нэгтгэх, тэдгээрт дүн шинжилгээ хийх, үр дүнгээ мэдээлж байх хэрэгтэй..

Дөрөвдүгээрт нь “Ажиглалт” энэ нь үл тохирол биш засах хэрэгтэй асуудал юм. Үүнд эрсдэлээ тооцох үнэлэх, эрсдэлийн менежмент хийх, нэгэнт гарчихсан үл тохирлуудын цаад учир шалтгааныг олж шийдэх, гал унтраах маягаар биш гэж ойлгоорой.

Мөн сайн тал, дадлуудыг байна. Тухайлбал сургуулийн хэмжээнд сурах орчин нөхцөл сайн, ариутгал, цэвэрлэгээ үйлчилгээ хангалттай. Зарим сургуулиудад мэргэшсэн аудиторууд багшилж, ажиллаж байна. Нэгжүүдийн стандартыг хэрэгжүүлэх ажилд идэвхтэй оролцож байна. За ингээд ректорын тушаалаар томилсон 21 аудиторуудын хийсэн тайланг товч танилцууллаа.

Ректор Б.Очирхуяг: Аудит хийх заавар, журам, аргачлал нь тодорхой биз дээ?

Ц.Эрдэнэбаяр: Аудит хийх журам, түүнд хамаарах маягтыг боловсруулчихсан байгаа.

Г.Оргилмаа: Үл тохирол бол заавал засна. Сайжруулалтыг бол стандарт хэрэгжүүлэх явцдаа хийгээд явах боломжтой. Аудиторууд анх удаа ажилласан, гэхдээ бид үнэлгээ явцаа харилцан ярилцсан тайланг нэгтгэх, дүгнэхдээ.

Б.Ганбат: Бидний боловсруулсан гарын авлага, түүнд шаардах баримт бичгүүдтэй сайтар уншиж танилцаарай гэж бүх нэгжийн удирдлагуудаас хүсэх байна. Хамаарах бүх мэдээллийг цахим шуудангаар илгээж байгаа. Ялангуяа гарын авлагын 4, 5, 6, 7 дугаар бүлэгт хамаарах шаардлагыг анхаарч үзээрэй.

#### ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. Багшийн сэтгэл ханамжийн судалгаа авахыг Багшийн хөгжил, суралцахуйг дэмжих төвд, ажилтны сэтгэл ханамжийн судалгаа авахыг Захиргаа, хүний нөөцийн газарт тус тус даалгаж цаашид тогтмол сэтгэл ханамжийн судалгааг тогтмол авч байх, мөн багш, ажилтны хөгжлийн хөтөлбөрийг боловсруулан мөрдөж ажиллахыг даалгав.

2. Боловсролын байгууллагын менежментийн тогтолцоо ISO:21001 стандартын гарын авлагыг батлахаар шийдвэрлэв.

3. Боловсролын байгууллагын менежментийн тогтолцоо ISO:21001 стандартын дотоод аудитын нэгдсэн тайланг дүгнэж үл тохирлоо засах, сайжруулах зөвлөмжид тусгасан саналуудыг хэрэгжүүлэхээр шийдвэрлэв.

ХУРАЛ 16 ЦАГТ ДУУСАВ.

ТАНИЛЦСАН:  
ХШУДАГ-ЫН ДАРГА




П.ЛХАМСҮРЭН

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН  
ДОТООД АУДИТОР



Н.МӨНХ-ЭРДЭНЭ

|                                                                                                          |                                                                                               |                                                                                                                                                                                                                                                                                                                                                               |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      |                                                                     |                        |          |       |
|----------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------|------------------------|----------|-------|
| МУИС-ийн менежментийн дүн шинжилгээний хурлын тэмдэглэл                                                  |                                                                                               |                                                                                                                                                                                                                                                                                                                                                               | Маягт №: NUM/EOMS/FMT/07                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             |                                                                     |                        |          |       |
| Хурлын огноо : 17/10/2025                                                                                |                                                                                               |                                                                                                                                                                                                                                                                                                                                                               | Хувилбар №: 01                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                       |                                                                     |                        |          |       |
| Цаг: 15-16 цаг                                                                                           |                                                                                               |                                                                                                                                                                                                                                                                                                                                                               | Огноо: 17/10/2025                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                    |                                                                     |                        |          |       |
| Байршил: МУИС-ийн I байр 320 тоот                                                                        |                                                                                               |                                                                                                                                                                                                                                                                                                                                                               | Танилцуулсан нь:<br>ХШУДАГ-ын дарга П.Лхамсүрэн,<br>ахлах мэргэжилтэн Б.Ганбат                                                                                                                                                                                                                                                                                                                                       |                                                                     |                        |          |       |
| №                                                                                                        | Хэлэлцэх асуудал                                                                              | Тэмдэглэл                                                                                                                                                                                                                                                                                                                                                     | Шийдвэр                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                              | Хариуцах ажилтан                                                    | Хугацаа                | Төлөв    | Бусад |
| 1                                                                                                        | Дотоод аудитын үр дүн                                                                         | Дотоод аудитын үр дүнг дараах удирдлагуудад тайлагнав. Үүнд:<br>Ректор Б.Очирхуяг<br>АТС-ийн захирал Ц.Амартайван<br>ШУС-ийн захирал Б.Болд-Эрдэнэ<br>БС-ийн дэд захирал М.Эрдэнэбат<br>ЦШГ-ын дарга А.Баатарбилэг<br>СХЧБГ-ын дарга С.Булгантамир<br>ОХГ-ын дарга Б.Цэцэнцолмон<br>ХАГ-ын дарга Ш.Мэндбаяр<br>СХГ-ын дарга С.Эрдэнэ<br>ХОГ-ын Д.Бадмаанямбуу | Дээд удирдлагын багаас дараах шийдвэрийг гаргав. Үүнд:<br>1. Үл тохирол бүхий багшийн сэтгэл ханамжийн судалгааг Багшийн хөгжил суралцахуйг дэмжих төвд, ажилтны сэтгэл ханамжийн судалгаа болон ажилтны хөгжлийн хөтөлбөр боловсруулах ажлыг Захиргаа хүний нөөцийн газарт даалгав.<br>2. Тус аудитаар илэрсэн сайжруулах боломжид хамаарах асуудлыг нягтлан авч үзэж үйл ажиллагаандаа тусгах саналтайгаар дэмжив. | Багш хөгжлийн суралцахуйг дэмжих төв, Захиргаа, хүний нөөцийн газар | Дараагийн хурлаас өмнө | Нээлттэй |       |
| 2                                                                                                        | Байгууллагын чанарын менежментийн тогтолцооны бодлого ба ББМТ-г нэвтрүүлэх зорилтын гүйцэтгэл | Дээд шатны удирдлагуудад гарын авлага болон баримтжуулсан мэдээллийг танилцуулав.                                                                                                                                                                                                                                                                             | Дээд удирдлага арын авлага болон баримтжуулсан мэдээллийг хянан, баталгаажуулав.                                                                                                                                                                                                                                                                                                                                     | Бүх ажилтнуудад хамааралтай                                         | Дараагийн хурлаас өмнө | Хаалттай |       |
| Тэмдэглэл хөтлөсөн:  |                                                                                               |                                                                                                                                                                                                                                                                                                                                                               | Танилцсан:                                                                                                                                                                                                                                                                                                                        |                                                                     |                        |          |       |